



61

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/32

Номгон

Баянхонгор сумын “Хэлний бодлогын  
үндэсний зөвлөлийн салбар зөвлөл”-ийг  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2016 оны “Салбар зөвлөл байгуулах тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны А/263 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Баянхонгор сумын Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд:

Боловсрол, соёл, урлагийн асуудал хариуцсан

мэргэжилтэн

Номгон ахлах сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш

Эрдэнэмандал ахлах сургуулийн Монгол хэл, уран

зохиолын багш

Эрдэм ахлах сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш

Соого Сейкео сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш

Насан туршийн боловсролын төвийн Монгол хэл, уран

зохиолын багш

Нарийн бичгийн дарга: Боловсрол Шинжлэх ухааны газрын Монгол хэл, уран

зохиолын боловсролын мэргэжилтэн

2. Хэлний бодлогын үндэсний салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

Захирамж 2023 он

• 621010861

3.Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга, Төсвийн шууд захирагч (Г.Хүрэлсүх)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны А/189 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Г.ЭНХБАЯР